

**ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА ЖАМЪЯНСЭНГЭЭГИЙН ЭРДЭНЭБОЛДЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/А	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
			3	4			
1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. "Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх"							
1.	Гаалийн зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар	90%	50%	<p>Гаалийн байгууллагын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд нийт 1663 зөрчил илрүүлж 3840.9 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 2673.1 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> 1578 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж, 3685.7 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 2571.3 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан. 46 зөрчлийн хэрэг бүртгэлт хийж, 155.2 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 101.8 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан. 39 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг харьяаллын дагуу цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. <p>Зөрчлийн улмаас 671.8 сая төгрөгийн үнийн дүн бүхий бараа, эд зүйлийг улсын орлого болгож, эрүүгийн шинжтэй хэрэгт хойшлуулшгүй ажиллагаа явуулж 400.5 сая төгрөгийн үнийн дүн бүхий барааг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.</p> <p>Нийт зөрчлийн тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 48.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчил 46.5 хувиар, зөрчлийн хэрэг бүртгэлт хийсэн хэргийн тоо 76.9 хувиар, гэмт хэргийн шинжтэй үйлдэл 129.4 хувиар тус тус өссөн байна.</p> <p>Шуудан илгээмж, карго ачаанд шалгалт хийснээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан [redacted] – 336 мл, [redacted] – 599.11 грамм, [redacted] – 33.4 грамм, [redacted] – 200 ширхэг, [redacted] – 1120 граммыг тус тус хураан холбогдох хууль сахиулах байгууллагад шилжүүлсэн байна.</p> <p>Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хороод болон Шуурхай хяналтын төвөөс энэ оны нэгдүгээр улирлын байдлаар иргэн, аж ахуйн нэгж, хууль, хяналтын байгууллагаас бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоотой ирүүлсэн гомдол мэдээллийг гаргуулан авч, тус мэдээллийн хүрээнд судалгаа, дүн шинжилгээ хийж, барааг мэдүүлэхтэй холбоотойгоор бүртгэгдсэн мэргэжилтний сургалтад бичиг баримтыг бүрэн, үнэн зөвөөр гаргуулан мэдүүлэх, буруу мэдүүлэхтэй</p>	2025.01.01-2025.06.10	100

				<p>холбоотой гарах үр дүн, зөрчлийн үр дагаврыг таниулах, мөн сургалтад хамрагдаж байгаа гаалийн байгууллагын суралцагч, албан хаагч нарт хяналт, шалгалтын зорилгоор ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж (хөдөлгөөнт болон суурин)-ийн нөөц бололцоог бүрэн ашиглах, гаалийн хяналт шалгалтад үр дүнтэй хэрэглэх, чадваржуулах чиглэлээр сургалтын хөтөлбөрт ахисан төвшинд тусгаж өгөх тухай саналыг дугаартай дотоод зурвасаар Сургалтын төвд, холбогдох судалгаа, дүн шинжилгээг хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах тухай 01-2/1982 дугаартай албан бичгийг Замын-Үүд дэх гаалийн газарт тус тус хүргүүлсэн.</p> <p>Гаалийн хяналтын улбар шар төлөвтэй бүрдүүлэлтэд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар дүн шинжилгээг хийж, удирдлагыг мэдээллээр хангах ажлын хүрээнд 04 дугаартай дотоод зурвасаар дэд дарга Г.Энхтайванд хүргүүлсэн.</p>		
				<p>Гаалийн болон бусад татвараас зайлсхийх зөрчлийн 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах ажлын хүрээнд 03 дугаартай дотоод зурвасаар дэд дарга Г.Энхтайванд хүргүүлж, чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллах тухай дугаартай дотоод зурвасыг ХБГ, БЦТ-д, дүн шинжилгээг хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж, гаалийн харилцаанд оролцогчдод чиглэсэн ажил арга, хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллах чиглэлийг дугаартай албан бичгээр Замын-Үүд дэх гаалийн газарт хүргүүлсэн.</p>		
2.	Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	50%	<p>- Гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд харьяа гаалийн газар хороодод 3 албан бичгээр холбогдох чиглэлийг хүргүүлж, урьдчилан сэргийлэх танхимын болон цахим 15 удаагийн сургалтыг зохион байгуулж, гаалийн зөрчил болон холбогдох бусад 8 мэдээллийг Монголын гааль цахим хуудсаар түгээж, хууль хяналтын бусад байгууллагуудтай мэдээлэл солилцож, хамтран ажиллахад хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан.</p> <p>- ОХУ-ын ХГА болон Сибирын болон Алс Дорнодын хууль сахиулах гаалийн газартай хамтран мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус тээвэрлэлтийг таслан зогсоох сургалт-дадлагын ажиллагааны төслийг харилцан тохиролцож, цаашид гарч болзошгүй гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.</p> <p>- Соёлын биет өвийг таньж тогтоох, хамгаалах, хууль бус үйлдэлтэй тэмцэх чиглэлээр ЗТГ, ОНХА нь Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран ЧХОУНБГ-т 05 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд, УБГТ, УХШИГТ-ын албан хаагчдад 05 дугаар сарын 10-ны өдөр, ЗҮГТ-т 06 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд үе шаттайгаар сургалтуудыг тус тус зохион байгуулсан. Албан хаагчид энэхүү сургалтад хамрагдсанаар соёлын өвийг хамгаалах тогтолцоо, мэдээллийн санд бүртгэлтэй түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, төрөл зүйл, тоон дүн, нэгдсэн системийн талаарх анхан шатны мэдлэгтэй болох, саатуулсан, хураагдсан соёлын өвийг шуурхай шинжлүүлж, дүгнэлт</p>	2025.01.01-2025.06.10	100

			100%		<p>гаргах, соёлын биет өвийг таньж тогтоох, авран хамгаалах, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад талаарх мэдээллийг авсан ач холбогдолтой сургалт болсон. Мөн дээрх сургалтын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын олон улсын болон бус нутаг, дотоодын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, шинээр бүртгэгдэж буй шинэ төрлийн синтетик бодис, зам суваг, манай улс руу нийлүүлж болзошгүй эрсдэл өндөртэй улс орны талаарх мэдээллийг өгч гаалийн хяналт, шалгалтад эрсдэл-төөцөж анхаарч ажиллах чиглэлийг давхар өгч ажилласан.</p> <p>- ГЕГ-ын ЗББНДБ, УБГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-ын удирдах албан тушаалтнуудад Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын дотоод, гадаад нөхцөл байдал, цаг үеийн асуудлаар хаалттай мэдээллийг 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, холбогдох мэдээллийг хүргэхийн зэрэгцээ бэлэн байдлыг хангаж ажиллахыг анхааруулж, зарим бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, гаалийн газар хороодыг уялдаа холбоотой хамтарч ажиллах чиглэл өгсөн.</p> <p>- ЦЕГ-ын Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх газар болон Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр улс хоорондын шуудан илгээмж ашиглан Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлд хамтран ажиллахаар төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улс хоорондын шуудан илгээмж, карго үйлчилгээ үзүүлэгч 50 гаруй иргэн, ААН-ийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулсан. Гаалийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, таслан зогсоох чиглэлд онцгойлон анхаарч Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын хяналтын бүсүүдийг орчин үеийн рентген төнөг төхөөрөмж болон мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх зориулалт бүхий тандагч багаж хэрэгслээр хангахыг зорин ажиллаж байна.</p> <p>- ЧХОУНБГГ-т Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх ажлын хүрээнд БНТУ, АНУ, Тайланд, Герман, Нидерланд, Вьетнам зэрэг улс орноос ирж байгаа зорчигчдын бие, гар тээш, биеэс тусдаа илгээгдэж байгаа ачаа тээшинд нарийвчилсан гаалийн хяналт шалгалтлыг зохион байгуулах, эрсдэлтэй орноос ирж байгаа түүвэр ачаанд хийх гаалийн хяналт, шалгалтыг сайжруулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж ажиллах тухай чиглэлийг [redacted] дугаартай албан бичиг,</p> <p>- ЧХОУНБГГ-т Карго терминал гаалийн хяналтын бүсэд байрлах гаалийн хяналт, шалгалтын рентген төхөөрөмжийг телехяналтын нэгдсэн системд холбох ажлыг ШХТ-тэй хамтран зохион байгуулах тухай [redacted] дугаартай албан бичиг тус тус хүргүүлсэн.</p>		
3.	Гадаад дотоодын байгууллагатай	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	50%		<p>- Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Оросын Холбооны Улсын Сибирийн болон Алс Дорнодын хууль сахиулах гаалийн газрын Хууль сахиулах чиглэлээр хил орчмын бус нутагт хамтран ажиллах асуудлаар зохион</p>	2025.01.01-2025.06.10	100

					<p>- ЦЕГ-т 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан "Үндэстэн дамнасан аюул заналхийллийн эсрэг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагаа" олон улсын эрдэм шинжилгээний хуралд ГЕГ-ын дарга Р.Отгонжаргалын хамт оролцож, Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагаа сэдвээр илтгэл тавьсан. Энэхүү хуралд Нэгдсэн Үндэстний байгууллагын Гэмт хэрэг, хар тамхитай тэмцэх албаны суурин төлөөлөгч болон Монгол улсад суугаа ОХУ, БНХАУ, АНУ, Япон, Солонгос, Турк, Итали элчин сайдын яамны цэрэг, цагдаа, хууль сахиулах байгууллага төлөөлөн суугаа дипломат ажилтнууд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагууд, генералууд оролцсон.</p> <p>- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх" үндэсний хорооны 2 дугаар хуралд оролцсон. Хуралдаанаар энэ оны эхний 5 сарын байдлаар хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ болон цаашид гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний талаар Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл танилцуулсан.</p> <p>- ЦЕГ-ын Хар тамхи мөнгө угаахтай тэмцэх газрын 25 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэхэд байгууллагуудын хамтын ажиллагаа" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцсон. ЦЕГ, НЦУГ, ШШЕГ, ЭЭХХЗГ, СЭМҮТ ДХИС болон холбогдох байгууллагын 100 гаруй төлөөлөл оролцсон тус хурлаар Монгол улсад бүртгэгдсэн шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын нөхцөл байдал, чиг хандлага, тулгамдаж буй асуудлын талаар оролцогчид хэлэлцүүлэг өрнүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа чухал болохыг онцлосон.</p>		
4.	Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй холбоотой гомдол, мэдээллийн шийдвэрлэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	<p>Тайлант хугацаанд Зөрчилтэй тэмцэх газарт 1800-1281 утсаар ирсэн 35, Засгийн газрын гомдол мэдээлэл хүлээн авах 11-11 төвөөс ирсэн 8 , иргэний бичгээр гаргасан 3 , Авлигатай тэмцэх газраас харьяаллын дагуу шилжиж ирсэн 2, нийт 48 гомдол, мэдээлэл ирснээс 29 гомдол, мэдээллийг харьяа гаалийн газарт шилжүүлж, 19 гомдол, мэдээллийг тус газарт шалган шийдвэрлэж хариуг хүргүүлэн ажилласан.</p> <p>Ирсэн гомдол, мэдээллийг ангилан авч үзвэл албан хаагчын ёс зүйтэй холбоотой гомдол 6, бараа тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлж гаалийн татвар бага төлж, шалгалт дутуу хийгдэж байгаа гэх 35 , хууль хяналтын байгууллагаас харьяаллын дагуу шилжиж ирсэн гомдол 2, санал 2 , шүүмжлэл 1, гаалийн байгууллагын үйл ажиллагаа, эрсдэлийн сантай холбоотой 1, ГБМ-ний үйл ажиллагаатай холбоотой гомдол 1 байна.</p> <p>Гомдол, мэдээллийн мөрөөр хийсэн шалгалтын дүнд гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн 3 зөрчил илрүүлж, 2 зөрчлийг</p>	2025.01.01-2025.06.10	100

	хамтран ажилласан байдал		90%	<p>байгуулах ээлжит ажлын наймдугаар уулзалтыг ОХУ-ын Новосибирск хотноо 2025 оны 7 дугаар сарын 01-ээс 03-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд өмнөх жилийн протоколын хүрээнд зохион байгуулагдсан ажлын хэрэгжилт болон хэлэлцэх асуудлын талаарх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн ажлын долдугаар уулзалтын хэлэлцээрийн хүрээнд тохиролцсон Протоколын 4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сургалт дадлагын ажиллагааг "хяналтын дор хүргэх" аргаар хамтран зохион байгуулахаар төлөвлөж, сургалт дадлагын ажиллагаанд оролцох Монголын талын бүрэлдэхүүний нэрс болон Монгол Улсын ГЕГ-аас нэмэлтээр оруулах саналыг 2025 оны [redacted] дугаар сарын [redacted] [redacted] дугаартай албан бичгээр ОХУ-ын талд хүргүүлсэн.</p> <p>- Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газрын Гаалийн цагдаагийн газар хоорондын 2023-2026 онд хамтран ажиллах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар санал солилцох, зөвлөлдөх ээлжит хуралдааныг 2025 оны 07 дугаар сарын 23-аас 25-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахаар төлөвлөгдөж зохион байгуулалтын бэлтгэл ажил хийгдэж байна.</p> <p>- Монгол Улсад цэргийн дээд генерал цол олгож эхэлсний 81 жилийн ой, "Монгол генералын өдөр"-ийг тохиолдуулан 2025.04.01-ний өдөр генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд "Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх бүс нутгийн болон дотоодын хамтын ажиллагаа" сэдвээр илтгэл тавьсан.</p> <p>- Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажлын албанаас 2025 оны [redacted] дугаар сарын [redacted] өдрийн [redacted] дугаартай албан бичгээр Монгол Улсын "Үй олноор хөнөөх зэвсэг түгээн дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль"-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Терроризмтой тэмцэх зөвлөлийн ажиллах журмын 2.3 дахь хэсгийг удирдлага болгон "Терроризмтой тэмцэх зөвлөл"-ийн хуралдааныг зохион байгуулж хамтарч ажиллахыг хүссэн албан бичиг ирүүлсний дагуу "Терроризмтой тэмцэх зөвлөл"-ийн гишүүдийн 2025 оны ээлжит хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Гаалийн ерөнхий газрын байранд ЗУГ, СХОГ, ААҮА-тай хамтран зохион байгуулж ажилласан. Ээлжит хуралдаанаар терроризмын аюул заналын эрсдэлийн үнэлгээний тайлан, терроризмтой тэмцэх мөрдөн шалгах ажиллагаанд интернэт, олон нийтийн цахим сүлжээг ашиглах нь, хиймэл оюун ухааны хэрэглээ ба терроризмын шинэ төрлийн аюул занал, кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдлын талаар болон НҮБ-ын Терроризмтой тэмцэх албанаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний явц байдлын мэдээллийг танилцуулсан. Түүнчлэн Терроризмтой тэмцэх зөвлөлийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлэлцүүлж батлуулж, Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бэлэн байдлыг хангах "Хаан шонхор" нэгдсэн дадлага сургуулийг 2025 оны 05 дугаар сард багтаан зохион байгуулахаар шийдвэрлэсэн.</p>	

					хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 31.2 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 15.6 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан, 76 сая төгрөгийн татвар ногдуулсан 1 үйлдлийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна.		
					- Зөрчлийн мэдээллийн сангийн бүрдлийг бүрэн хангуулах, санг бодитой болгох, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, зөрчилд холбогдсон барааг хууль бусаар нэвтрүүлсэн арга, хэрэгсэл, үйлдлийг баримтжуулах, албан хаагчдыг мэдээллээр хангах, сургалтын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор зөрчлийн программд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлыг зохион байгуулж зөрчлийн мэдээллийн санг ашиглахад гарч буй хүндрэлтэй, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд болон зөрчлийн программыг сайжруулах, шинэчлэлт, өөрчлөлт хийх ажлыг эхлүүлэн программын бодлогын даалгавар боловсруулж шийдвэрлэх ажлыг удирдлагаар хангаж ажилласан.	2025.01.01- 2025.06.10	100
5.	Зөрчлийн мэдээллийн санд хяналт тавьсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	80%	50%	- CAIS программын зөрчлийн мэдээллийн санд тулгуурлан дараах судалгаа, дүн шинжилгээг хийж холбогдох мэдээллийг харьяа гаалийн газар, хороодод албан бичгээр, ГЕГ-ын ЗББНДБ-д дотоод зурвасаар хүргүүлэхэд хяналт тавьж удирдлагаар ханган ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> Хорио цээрийн хяналт, шалгалтын явцад илрүүлэн шийдвэрлэсэн зөрчилд 2022-2024 оны байдлаар дүн шинжилгээг хийж, удирдлагыг мэдээллээр хангах ажлын хүрээнд 02 дугаартай дотоод зурвасаар дэд дарга Г.Энхтайванд хүргүүлж, дүн шинжилгээг хяналт шалгалтын зорилгоор ашиглаж цаашид зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, ажлын байрны сургалтыг тасралтгүй зохион байгуулж, үр дүнг тооцож, хийгдсэн ажлын мэдээллийг тайланд тусгаж ажиллах чиглэлийг [REDACTED] дугаартай албан бичгээр харьяа гаалийн газар, хороодод, чиг үүргийн хүрээнд хяналт тавьж, зөвлөмж чиглэлээр хангаж ажиллах тухай [REDACTED] дугаартай дотоод зурвасыг Хорио цээрийн хэлтэст, 2025 оны 1 дүгээр улирлын гаалийн болон бусад татвараас зайлсхийх зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах ажлын хүрээнд 03 дугаартай дотоод зурвасаар дэд дарга Г.Энхтайванд хүргүүлж, чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллах тухай [REDACTED] дугаартай дотоод зурвасыг ХБГ, БЦТ-д, дүн шинжилгээг хяналт бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглаж, гаалийн харилцаанд оролцогчдод чиглэсэн ажил арга, хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллах чиглэлийг [REDACTED] дугаартай албан бичгээр Замын-Үүд дэх гаалийн газарт, Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024 онд илрүүлэн шийдвэрлэсэн зөрчлийн байдалд КАИС программын зөрчлийн сан болон тус төвийн ГУБ нарын зөрчил шалган шийдвэрлэсэн материалд тулгуурлан дүн 		

					<p>шинжилгээг хийж, холбогдох мэдээллийг тус төвийн үйл ажиллагаанд гүйцэтгэх хяналт шинжилгээ, үнэлгээний багт тус тус хүргүүлсэн.</p> <p>- Нэгжийн чиг үүргийн хүрээнд харьяа гаалийн газар, хороодын бүрдүүлэлтэд онилгоо хийх ажлыг удирдан зохион байгуулснаар "Гааль зөвшөөрөв" "татвар төлсөн" төлөвт хийсэн дахин шалгалтаар гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн 18 зөрчил илрүүлж 138.2 сая төгрөгийн татвар нөхөн төлүүлж, 69.1 сая төгрөгийн торгууль ногдуулан барагдуулсан нь өмнөх оны мөн үеэс зөрчлийн тоо 80 хувиар, торгуулийн дүн 65.7 хувиар, нөхөн төлүүлсэн татварын дүн 65.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.</p>		
Зорилт 2. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"							
					<p>Зөрчилтэй тэмцэх газрын албан хаагчид 5 төрлийн судалгаа, дүн шинжилгээг хийж танилцуулгаар ГЕГ-ын дарга, дэд даргад хүргүүлж удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж, дүн шинжилгээг хяналт шалгалтын зорилгоор ашиглаж, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах чиглэлийг харьяа гаалийн газар, хороодод албан бичгээр, ГЕГ-ын ХБГ, БЦТ, ХЦХ-т чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллах тухай дотоод зурвасыг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Гаалийн болон бусад татвараас зайлсхийх зөрчлийн байдал, • Хорио цээрийн хяналт шалгалтын явцад илрүүлэн шийдвэрлэсэн зөрчлийн байдал, • Гомдол, мэдээлэл шийдвэрлэлт, • Улбар шар төлөвт сонгогдсон бүрдүүлэлт, • БЦТ-ийн илрүүлэн шийдвэрлэсэн зөрчлийн байдал. <p>Дараах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан. Үүнд:</p> <p>- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооний 2024 оны үйл ажиллагааний төлөвлөгөөний биелэлтийг [redacted] албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Мөнгө угаах терроризмтэй тэмцэх зөвлөлийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд гаалийн байгууллагаас хэрэгжүүлэх ажлын саналыг [redacted] дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн.</p> <p>- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн төлөвлөгөөний төсөлд тусгах ажил, арга хэмжээний саналыг [redacted] дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын 2023 оны "дүгээр сарын ний өдрийн гоот тушаалын хавсралтаар батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-149 дэх ажил (Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын давхардлыг арилгах, улмаар хуульд заасан 15 сая төгрөгөөс доош хэмжээгээр гаальд мэдүүлээгүй олон давтамжтай нэвтэрч буй зорчигчдын хөдөлгөөнд авах арга хэмжээг тодорхой</p>	2025.01.01-2025.06.10	100
1.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%			

					<p>болгох)-ын хүрээнд гаалийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй ажлын тайланг 01/2037 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Гаалийн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.3 дугаар ажлын гүйцэтгэлийг эхний хагас жилийн байдлаар гаргаж ЗУГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.</p> <p>- Гаалийн байгууллагын "Шударга байдлын үнэлгээ"-г 2025 онд сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган дотоод зурвасаар ЗУГ-т хүргүүлсэн,</p> <p>- Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган дотоод зурвасаар ЗУГ-т хүргүүлсэн,</p>		
					"Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангаж Монголбанкны 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн	2025.01.01-2025.06.10	100
2.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	<p>дугаартай албан бичгийн дагуу Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2019. ний өдрийн дугаар хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавих чиглэлийг харьяа гаалийн газар, хороодод 2025 оны дүгээр сарын ны өдрийн дугаартай албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж байна.</p>		
					ГЕГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/123 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бүтцээр тус нэгжид 8 гаалийн улсын байцаагч ажиллахаар батлагдсан бөгөөд 2024 онд 4 гаалийн улсын байцаагч ажиллаж байснаар "Үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль бус барааны эргэлт, худалдааны луйвар, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хэрэгжүүлэх" үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болох хүний нөөцийн эрсдэлтэй гэж үзсэн.	2025.01.01-2025.06.10	100
3.	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	66%	50%	<p>Иймд албан хаагчдын тогтвортой, мэргэшсэн байдал, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хүний нөөцийн эрсдлийг бууруулахад чиглэж сул орон тоог нөхөх зорилгоор харьяа гаалийн газар, хороодод ажиллаж байгаа албан хаагчдаас албан тушаалын тодорхойлолтод заагдсан мэргэжлийн индекс, тавигдах бусад шаардлагыг хангах албан хаагчийн судалгаа явуулснаар 2025 оны 4 дүгээр сараас харьяа гаалийн газраас 2 албан хаагч, ГЕГ-ын ХТМУТХ-ээс 2 албан хаагч тус газарт томилогдсоноор нийт 7 гаалийн улсын байцаагч нэгжийн хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Мөн энэ оны 4 дүгээр сараас тус нэгжийн гаалийн улсын ахлах байцаагч ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд ингэснээр албан хаагчдыг идэвхижүүлэх, зохион байгуулах, чиг үүргийг хуваарилах зэрэг дотоод зохион байгуулалтын эрсдэл үүсэж байна.</p> <p>Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах тухайлбал ажил хэвийн явуулахад шаардлагатай техник хэрэгслээр бүрэн хангагдах, ажлын өрөөний агааржуулалт, гэрэлтүүлгийг сайжруулах, ариун цэврийн өрөөг хүйсээр ялгаж</p>		

					тусгаарлах зэрэг шаардлага үүсэж байгаа нь албан хаагчдын ажиллах нөхцөл хангамж эрсдэлтэй байгааг харуулж байна. Сүүлийн хагас жилд дээрх асуудлуудыг холбогдох нэгжүүдэд хандаж шийдвэрлүүлэх чиглэлээр ажил зохион байгуулна.		
4.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100%	50%	Тайлант хугацаанд Захиргааны удирдлагын газраас 1, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2, Татвар, орлогын газраас 1 үүрэг даалгавар, ХШУДАГ-аас 33 зөвлөмж, ЗУГ-аас цаг үеийн шинжтэй 2 даалгавар ирүүлснийн дагуу хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг хугацаанд нь Захиргаа дотоод ажлын системийн үүрэг даалгавар цэсэнд оруулсан. 2 үүрэг даалгаврын хугацаа болоогүй байгаа. Үүрэг даалгаврын хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. - ГЕГ-ын даргын 2025.04.07-ны өдөр баталсан "Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө"-ний 1.9 дэх ажлын хүрээнд хийгдсэн ажлын биелэлтийг ТОГ-т хүргүүлсэн. - ХШУДАГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулж, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Цаг үеийн шинжтэй 2 хандивын аргажэмжээн тус газрын албан хаагчид бүрэн хамрагдсан.		
5.	Цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	Тайлант хугацаанд ажиллавал зохих 107 өдөр 856 цагаас 107 өдөр 856 цаг ажилласан. Цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, зайлшгүй шаардлагатай үед CERP-д тухай бүр хүсэлтээ оруулан баталгаажуулж ажилласан.		100
6.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	50%	- Тайлант хугацаанд тус нэгжээс зохион байгуулсан ажил, арга хэмжээ, нөхцөл байдлын танилцуулгуудыг ГЕГ-ын дарга болон дэд даргад хүргүүлж, удирдлагыг мэдээллээр тасралтгүй хангаж ажилласан. Нийт 22 удаагийн танилцуулгыг ГЕГ-ын даргад, 5 удаагийн танилцуулгыг дэд даргад хүргүүлсэн. - Хууль хяналтын болон төрийн бусад байгууллагууд, ААН, иргэдээс ирүүлсэн 513 албан бичиг, 7 өргөдөл, 3 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариуг хүргүүлэн ажилласан. - ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар хороодод 14 албан бичиг, 3 дотоод зурвасаар чиглэл, зөвлөмж хүргүүлж биелэлтийг хангуулан ажилласан.		100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/А	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.	Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөл, Захиргааны	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Хууль, журмын мэдлэг	Холбогдох хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт, журам заавартай тухай бүр	2025.01.01-2025.06.10	100

зөвлөл, Сахилгын хорооны гишүүний хувиар холбогдох хууль, журмын мэдлэгээ судалж дээшлүүлэх.		-	дээшилсэн байна.	танилцаж, судалж гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлсэн.		
--	--	---	------------------	--	--	--

Тайлан гаргасан:

Зөрчилтэй тэмцэх газрын дарга



/Ж.Эрдэнэболд/

2025. 06. 12.

**ГАЗРЫН ДАРГА ЖАМЪЯНСЭНГЭЭГИЙН ЭРДЭНЭБОЛДЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Зөрчилтэй тэмцэх газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	100%	65

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөл, Захиргааны зөвлөл, Сахилгын хорооны гишүүний хувиар холбогдох хууль, журмын мэдлэгээ судалж дээшлүүлэх.	100%	15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	12
2.	Удирдан зохион байгуулах	13
3.	Асуудал шийдвэрлэх	12
4.	Манлайлах	12
5.	Багаар ажиллах	12
6.	Харилцаа	13
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		12

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	65
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15

3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	12
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	-
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		92

Үнэлгээ өгсөн:

ГЕГ-ын дарга

Төсвийн шууд захирагч

/Р.Отгонжаргал/

2025.06.25

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

ЗТГ-ын дарга

Нэгжийн дарга:

/Ж.Эрдэнэболд/

2025.06.10